



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/274

Булган сум

Булган аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд
“Хурдан морины бүсийн уралдаан” зохион байгуулах
тов батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.9., 13.1.10 дахь заалт, Монголын морин спорт уяачдын холбооны 2019 оны VII Их хурлын А/20 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булганхангай морин спорт уяачдын холбооны ирүүлсэн саналын дагуу 2025 онд зохион байгуулах аймгийн хурдан морины бүсийн уралдааны товыг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн хурдан морины бүсийн уралдааны үеэр оролцогчдын аюулгүй байдал, хэв журмыг хангаж ажиллахыг Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, сумын Засаг нарт даалгасугай.

3. Аймгийн хурдан морины бүсийн уралдааны хөтөлбөр, хуваарийн дагуу аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллахыг Булганхангай морин спорт уяачдын холбоонд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
01 дүгээр сарын 29-ны/ний өдрийн
А/27 дугаар захирамжийн хавсралт

**БУЛГАН АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2025 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ
“АЙМГИЙН БҮСИЙН УРАЛДААН”-НЫ ТОВ**

Д/д	Уралдааны нэр	Уралдах нас	Уралдаан зохион байгуулах газар, хугацаа	Хариуцах эзэн
1	2	3	4	5
1	“Хангал хурд-2025” аймгийн бүсийн хаврын уралдаан	• Азарга • Их нас • Соёолон • Сонгомол дээд нас	Хангал суманд 5-р сарын 2-нд	Хангал сумын ЗДТГ “Хийморь” МСУХ
2	“Хульжийн хурд-2025” аймгийн бүсийн хаврын уралдаан	• Азарга • Их нас • Соёолон • Сонгомол дээд нас	Могод суманд 5-р сарын 3-нд	Могод сумын ЗДТГ “Хульжийн хурд” МСУХ
3	“Булганхангайн хурд-2025” аймгийн бүсийн хаврын уралдаан	• Хязаалан • Шүдлэн • Даага • Сонгомол дунд нас • Сонгомол бага нас	Булган суманд 5-р сарын 4-нд	“Булганхангай” МСУХ
4	“Орхон хурд-2025” аймгийн бүсийн хаврын уралдаан	• Хязаалан • Шүдлэн • Даага • Сонгомол дунд нас • Сонгомол бага нас	Орхон суманд 5-р сарын 10-нд	Орхон сумын ЗДТГ “Орхон-Ажнай” МСУХ
5	“Буурлын хурд-2025” аймгийн бүсийн хаврын уралдаан	• Хязаалан • Шүдлэн • Даага • Сонгомол дунд нас • Сонгомол доод нас	Тэшиг суманд 5-р сарын 11-нд	Тэшиг сумын ЗДТГ “Буурлын хурд” МСУХ
6	Аймгийн “Булганхангайн шигшмэл хурд” хурдан морины уралдаан	• Азарга • Их нас • Сонгомол дээд нас	Булган суманд 7-р сард	“Булганхангай” МСУХ